



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/263

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мал хамгаалах сангийн үйл ажиллагаа болон 2023 онд бэлтгэсэн өвс тэжээлийн чанар байдалд хяналт хийж, цаашид авах арга хэмжээний санал танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Я.Эрхэмбаяр (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд:

Б.Батнасан (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Д.Чинзориг (Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хүнс, хөдөө аж ахуйн бодлого үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)


Б.Одончимэг (АИТХ-ын Ажлын албаны бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: С.Анхбаяр (Мал хамгаалах сангийн нярав)

2.Өвс, тэжээлийн чанар байдалд дүгнэлт гарган, санал боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Я.Эрхэмбаяр) -д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийн түр гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

6712011575